

УДК 94(517)

DOI: 10.22162/2587-6503-2020-2-14-139-152

Монгол домог дахь Мин улсын хаадын өгүүлэмж (= Устные предания монголов о правителях династии Мин)

*Бата Даржагийн*¹

¹ Северо-Западный университет национальностей (д. 1, Шибей Шинхун, Ланьчжоу, 730030 Ганьсу, КНР)

Northwest University for Nationalities (1, Xibei Xinxun, Lanzhou, Gansu 730030, China)

доктор филологических наук, профессор

Ph.D. (Philology), Professor

E-mail: batu602@hotmail.com

© КалмНЦ РАН, 2020

© Бата Даржагийн, 2020

Аннотация. В устной традиции монголов сохранилось много легенд и преданий не только о Чингис-хане и времени существования монгольской династии Юань, но и о первом императоре Чжу Юаньчжане (1368–1398) пришедшей ей на смену династии Мин. В этих преданиях, во-первых, говорится о том, что Чжу Юаньчжан не имел благородного происхождения, а был сыном бедного простолюдина и стал императором по воле случая. Во-вторых, в них утверждается, что императоры династии Мин были монголами по своему происхождению. В-третьих, эти предания и легенды по форме и содержанию являются традиционными для устного творчества монголов. Цель данной статьи — ввести в научный оборот сюжеты и темы монгольских исторических легенд и преданий об императорах династии Мин. Многие тексты легенд и преданий были записаны автором статьи у Агванчойдора и вошли в содержание книги «Устная история монголо-тибетского буддизма», а также у других информантов в ходе экспедиционных выездов.

Ключевые слова: монголы, легенды и предания, династия Мин, Агван-чойдор

Благодарность. Материалы статьи апробированы на Международной научной онлайн-конференции «Монголоведение в начале XXI в.: современное состояние и перспективы развития – II», проведенной при финансовой поддержке РФФИ (проект № 20-09-22004) и частичной поддержке гранта Правительства РФ (№ 075-15-2019-1879).

Для цитирования: Бата Даржагийн. Монгол домог дахь Мин улсын хаадын өгүүлэмж (= Устные предания монголов о правителях династии Мин) // Бюллетень Калмыцкого научного центра РАН. 2020. № 2. С. 139–152. (На монг.). DOI: 10.22162/2587-6503-2020-2-14-139-152

UDC 94(517)

DOI: 10.22162/2587-6503-2020-2-14-139-152

Oral Legends of the Mongols about the Rulers of the Ming Dynasty

*Bata Darzhagiin*¹

¹Northwest University for Nationalities (1, Xibei Xinxun, Lanzhou, Gansu 730030, China)

Ph.D. (Philology), Professor

E-mail: batu602@hotmail.com

© KalmSC RAS, 2020

© Bata Darzhagiin, 2020

Abstract. In the oral traditions of Mongols there are a lot of legends and stories not only about Genghis Khan and the period of Mongolian Yuan dynasty, but also about the first emperor of the succeeding Ming dynasty Zhu Yuanzhang (1368–1398). These stories, first of all, tell that Zhu Yuanzhang was not of the noble origin, he was the son of a common man and became the king by good fortune. Secondly, they state that the Ming dynasty emperors were Mongols by their origin. Thirdly, all these stories and legends in their form and content are typical for Mongolian folklore. The goal of this article is to introduce the plot and themes of the Mongolian historic legends and stories about the Ming

dynasty emperors. Most of the texts of legends and stories were recorded by the author from Agvanchoidor (they were included into the book “The Oral History of Mongolian-Tibetan Buddhism”) and also from other informants during expeditions.

Keywords: Mongols, legends and stories, Ming dynasty, Agvanchoidor

Acknowledgement. The article was presented at the international scientific online conference “Mongolian Studies at the beginning of the 21st century: Current State and Development Prospects – II”, held with the financial support of RFBR (project № 20-09-22004) and partial support of the Russian Government Grant (№ 075-15-2019-1879).

For citation: Bata Darzhagiin. Oral Legends of the Mongols about the Rulers of the Ming Dynasty. *Bulletin of the Kalmyk Scientific Center of the RAS*. 2020. No. 2. Pp. 139–152. (In Mong.). DOI: 10.22162/2587-6503-2020-2-14-139-152

Монгол домог дахь Мин улсын хаадын өгүүлэмж

Нэг. Ардын дунд уламжилж байгаа Мин улсын анхны хааны тухай домог

Хөхнуурын газрын шинжийг өгүүлсэн тухай аман түүхэнд ийм нэг домог бий.

«Хаан хүн бол ерөөс газрын шинжийг их анхаардаг байх ёстой. Мин улсын анхны хаан Жу Хон Уи-гийн өвөг нь маш ядуу хүн байжээ. Тэр нь явж байгаад нэг газарт үхчихэж гэнэ. Тэгээд олон хүн түүний хүүрийг дээсээр чирж яваад нэг газарт оршуулья гэж нэг гүн биш устай газраар гатлах гээд явтал, газрын дунд хүрээд дээс нь тасарч, тэр хүүрийг нааш нь гаргах ч үгүй, цааш нь явах ч аргагүй болжээ. Ингээд тэр дунд явсан нэг хүн нь хэлсэн нь: “Одоо өөр аргагүй, мөн энэ газар нь оршуулья” гээд хүрз авчирч, усыг нь зайлуулж газар малтаад тэнд нь булж тавьжээ. Гэтэл энэ газрын шинж нь хишиг буян сайтай байснаас хүүгийнх нь хүү нь хаан суужээ гэдэг» [Бат 2016].

Бас нэг домогт:

«Мин улсын анхны хаан ядуу зүдүү тэнэж яваад нэг ядуу айлд хүрчээ. Тэр айлд нэг өвгөн охинтойгоо байж гэнэ. Тэгээд охин нь тэр хаанд нэг энгийн хоол хийж өгжээ. Хаан их баясаж, ертөнц дээр

ийм сайхан амттай хоол байдаг болов уу? гэж боджээ. Тэгээд тэр хоол нь санаанаас нь гардаггүй байв. Хожим тэр хүн Мин улсын хаан болчихоод, нэг өдөр тэр хоол нь санаанд орж, нөгөө өвгөн, охин хоёрыг сураглуулжээ. Тэгж, тэгж тэр айлын хүүхнийг олж авав. Охны эцэг нь нас барсан байжээ. Тэгээд тэр хүүхнээр нь мөн тэр жилийн хийсэн хоолыг хийлгэсэнд тэр нь ямар ч амтгүй эв энгийн хоол байж гэнэ» [ХСМ-1].

Мөн Мин улсын хаан гэж дурдсангүй боловч, тэр үед бий болсон магад гэмээр бас нэг домог бий.

«Урд монголчууд хаан төр бариад хятадыг их дарладаг байжээ. Тэгээд тэднийг хонины арьсан дээр хооллуулдаг байжээ. Үүнд хятадууд гуйсан нь, ”Бид шавраар аяга хийж болох уу? гэсэнд монголчууд зөвшөөрч, тэр аягыг нь янпи (хонны арьсан) шаазан гэж нэрлэх болжээ. Янпи шаазан гэж хятад хүний хоол иддэг тэр дарвагар шаазангийн ирэл нь тийм учиртой гэнэ» [ХСМ-2].

Мөн найман сарын арван тавны хятадын баяр ч бас энэ домогтой холбогдож яригдсан байдаг.

Мин улсын анхны хааны тухай эхний домог нь газрын шинж, хувь заяатай холбогдож байгаа боловч, сүүлийн домогт ёжилж хошигносон шинж хийгээд монголын хаан төртэй холбогдсон жишээ байдаг. Ерөнхийдөө «Мин улсын хааны уг язгуур ядуу хоосон хүн байсан» гэдэг нь эдгээр домгуудын нийтлэг онцлог болох бөгөөд хаан төрийн тухай ардын ухамсар, домог ярины ерөнхий шинжийг хадгалсан байна. Өөрөөр хэлбэл: Ядуу зүдүү хүн ч бас хаан болж, төр барьж болох ёсыг харуулсан байна. «Эр хүн туг ч барина, тугал ч хариулна» гэдэг үгийн нөгөө нэг санаа шинээр илэрч байна.

Ардын ярианаас гадна, аман түүхийн материалд ч бас Мин улсын анхны хааны тухай өгүүлсэн нь бий. Мин улсын үед Юань улсын үеийн жин, лангийн тооллыг огт хувиргалгүйгээр хэрэглэжээ. Учир нь Мин улсын эхний хаан болох Жү Хун У (Жү юань жан) нь угтаа сүмд лам байсан юм. Тэгээд тэр Мин улсын хаан болж Юань улсын Тогоонтөмөр хааны хатныг хатан болгож авав. Тэр хатан нь их гоё сайхан хүн байсан тул Мин улсын хаан нь түүний үгээс гардаггүй бөгөөд хатны захисан зүйлээр явдаг

байжээ. Тэр хатан нь уг нь хааны хатан байсан тул төр гүрний явдлыг их ойлгодог байв. Тиймээс тэрээр Мин улсын хаан Жү Юань Жанд хэлсэн нь:

«Төр солигдож болно. Хаан солигдож болно. Гэвч хүний заншил ёсыг сольж болохгүй. Тиймээс хуучин ёс заншлыг нь дагуулж төрийг барих хэрэгтэй» гэжээ. Ингээд Мин улсын хаан нь Юань улсын үеийн их олон хууль ёс, тогтоол дүрмийг уг ёсоор нь явуулж, өөрчлөлт хийсэнгүй» [Бат 2011: 25]. Энд ярьж байгаа «төр барих, төрийг засах» ёсны талаар бас нэг жишээ бий. Тэр нь юу гэвэл,

«Төрийг авахад амар, харин төрийг засхад их хүчир байдаг ажээ. Зарим нь төрийг бариад шашныг барихгүй, зарим нь шашныг бариад төрийг барихгүй, зарим нь төр, шашин хоёулыг бариад, хүний амьдралыг барихгүй байдаг. Төр шашин амьдрал гурвыг зэрэг барих ёстой. Ингэвэл хаан төр их удаан байж чадна. Манжийн төр Дундад улсыг гурван зуу шахам жил ноёрхож, арван гурван хаан суусан байна. Манж нар Мин улсаас төрийг авсан биш, харин тариачны бослогын түрүү Ли Зичингийн гараас төрийн эрхийг авсан байна.

Ли Зичин бослогын цэргийг удирдаад Мин улсыг мөхөөж, хаан суужээ. Тэгээд, Хатан голын хойт биеийг Ү Сан Гүй авч, Хатан голын өмнө талын шим тэжээл, ус мөрөнтэй газрыг Ли Зичин авжээ. Ингээд Ли Зичин өөрийгөө хаан өргөмжилжээ. Тэгээд тэр 8 жил хаан суух заяатай байсан боловч сар бүр нэг цагаалж, 8 сар цагаалж, 8 жил хаан суух буянаа алджээ. Ли Зичин хааны дэргэд Чэнь Юань Юань хэмээх гоё хүүхэн байсаныг Ү Сан Гүй булааж авч яваад, тэр хоёрын дунд дайн үүсэж, эцэст Ли Зичин ялагдаж, манжийн төр тогтжээ.

Манжийн төр тогтож бататгасан нь Мин улсын түшмэл Хүн Чэнь Ай гэдэг хүн төрийг засах бодлогыг ярьж өгсөн байна. Төрийг засахад хуучин дэг журмыг өөрчлөхгүйгээр шинэ бодлогыг явуулдаг байна. Учир нь урд төрийн дэг журамд хүмүүс дасч дадсан тул олон шинэ өөрчлөлт нь хүний сэтгэлийг үймүүлдэг байна. Монгол улс тийм их хүчтэй байсан ч Дундад улсыг манжийн адил удаан ноёрхож чадсангүй, сая 90 жил болжээ. Учир нь Монгол Юань улс их олон талын өөрчлөлт хийжээ. Манж Чин улсын үед, Манжийн хаан гагцхүү Монголтой л дайн хийснээс биш, Хятад буюу бусадтай дайн хийгээгүй нь түүний төрийн бодолготой нь нягт холбоотой

юм. Манж чин улсын засгаас Хятадыг бичгээр дарсан. Хэн эрдэмтэй байвал түүнийг ноён болгоно, хүн нь сайн мууг үл ойшооно. Төвдийг ламаар дарсан. Олон богд хувилгааныг тодруулсан юм. Монголыг ураг барилдах, хааны хүүхнийг өгөөд захирсан юм. Алша ван бол Манж чин улсын тавнан байх ёстой. Тэгээд цэргийг захирч, бослогыг дарж хил хязгаарын амрыг хамгаална гэжээ» [Бат 2011: 227–228].

Эдгээр домог ба аман материал нь адил бус төрийн явдлыг ярьж байгаа ч Тогоонтөмөр хааны Хон хэрээд хатны дээр өгүүлсэн сургаал нь Чин улсад ч хүчтэй нөлөөлсөн нь ил байна.

Хоёр: Мин улсын хаан Юн Логийн домог

Мин улсын хаан Юн Логийн тухай Монгол түүхийн сурвалж бичиг болгонд бараг тэмдэглэж байгаагаас гадна бас амаар уламжилсан домог бий. «Ёст хаан Юн Логийн домог» гэж алдаршсан талаар Монгол улсын нэрт эрдэмтэн Ш. Гаадамба «Монголын уран зохиолын тойм»-ын хоёрдугаар дэвтэрт өгүүлэн анх танилцуулсан байна. Тэдгэр жишээгээс авч үзвэл, эрдэмтэн Ш. Гаадамбаас :

Энэ домог «Хураангуй Алтан товч», «Чингис хааны цадиг», «Лу. Алтан товч», «Асрагч нэртийн түүх» зэрэг судар бичгийн дотор орж уламжлан иржээ. Мөн энэ домгийг түүхч Рашпунцаг «Монгол улсын түүх» (Болор эрхи) зохиолдоо иш татаж эргэлзсэн тайлбар хийсэн байна. Эдгээр эх бичгүүд хоорондоо төдийлөн ялгаагүй. Зарим нь жишээлбэл «Хураангуй алтан товч», «Асрагч нэртийн түүх» хоёрт байгаа эх үсэг, үг зөрөхгүй тохирно. Гэвч бидний санахад «Лу.Алтан товчид» байгаа эх илүү утга учир бүрэн сайн эх юм.

Энэ домгийн агуулга нь Тогоон Төмөр хааны зугтааж гарахад Хонхэрээд хатан нь гурван сар болсон жирэмсэн байж олзлогдсон ажээ. Түүнийг Хун-ү хаан хатан болгож асарсанд хатан «Миний хүү долоон сар болж гарвал дайсны хүү гэж ална. Арван сар болж гарвал өөрийн хүү гэж асарна» гэж бодоод «Арван сар болгож төрүүлж хайрла» гэж тэнгэрт залбирсанд тэр ёсоор арван сар болж төржээ. Хааны хятад хатнаас бас нэг хүү гарчээ. Хаан «хоёр луу ноцолдож зүүн луу дийлэв» гэж зүүдэлснийг ёрчин «Монгол хүү хаан ширээнд чинь суух ёр» гэж тайлав. Хаан сэжиглэж монгол хатны хүүг хэрмийн гадна хөх хот барьж суулгав. Хун-ү хааныг хальсны хойно

хятад хатны хүү хаан сууж дөрвөн жил болж байтал монгол хатны хүү цэрэг бэлтгэн байлдаж хятадын хааныг хүзүүнд нь мөнгөн тамга дарж хөөгөөд, Мин улсын төрийг эзэлж хятадын хаан болсонд их Мин улсын Ёст хаан Юн Ло гэж алдаршив»

гэсэн зүйл болно. Энэ домгийн утга санааг ЗХУын эрдэмтэн Л. С. Пучковский «13–17-р зууны монголын феодалын түүх бичиг» гэсэн өгүүлэлдээ: «Энэ домог Мин улсын эзэн хаад монголын эзэн хаадаас үүсэлтэй, тэдний удам угсааг залгамжлагчид мөнгөж батлах зорилготой юм» гэж тодорхойлсон байна. Энэ нь ерөнхийдөө зөв зүйтэй санал юм. Гэвч энэ домог түүхийн үнэн бодит үндэс, ортой баримт бий юу? Аль эсвэл хоосон санаанаас зохиосон оргүй худал зүйл үү? гэдэг асуудал сонирхолтой юм. Энэ талаар монголын түүхч Рашпунцаг дээр дурдсан тайлбартаа: «Би санавал Шүн-Ди (Тогоон Төмөр) хаан Дайду (Бэйжин) хотоос гарахдаа гэнэнээр бачимдсангүй, урьдаар мэдсээр аж. Ингээд зугтаан гарсан тул юунд хатнаа орхих ажээ. Тийм атал Хятад бичигт шаргачин тахиа жил Мин улсын цэрэг гарч намрын сүүл сард хааны ач Майдарвал, Даш, Төмөр хааныг барив гэснийг үзвэл бас нийлэлцэх мэт» гэж бичжээ. Рашпунцаг энэ домгийн үнэн мөнтэйг төдий л итгэхгүй боловч бас ортой зүйл магадгүй гэж эргэлзсэн ил байна. Харин Тогоон Төмөр хаан Рашпунцагийн баталж байгаа шиг бачимдалгүй учирт тайван зугтаасан гэж итгэхэд бэрх тул зарим хатнаа орхисон байхад үгүй болох газаргүй.

Ер нь Мин улсын хааны дотроо Юн Ло монголыг ихэд сонирхсон монголын түүх судар, түүний дотор «МНТ»-ны эхийг хүртэл номын сандаа олж хадгалсан байсан нь сонирхолтой бөгөөд нэг учиртай байж магадгүй. Ер нь энэ домогт үндэс сурвалж болсон нэгэн түүхэн явдал эрхбиш бий биз. Энэ домгийн түүхэн үндэс нь бидний санавал Юн Ло хаан өөрийн ач дүүгээ ширээнээс буулгаж Нанжингаас Бэйжинд нийслэлсэн явдал мөн байх. Энэ явдал 1406 онд болсон гэж архимандрит Палладий (Кафаров) Нууц товчооны орос орчуулгын оршилд бичсэн юм [Дамдинсүрэн, Цэнд 1983: 334–336].

Тэр үг нь: «Юань чао ми ши анх Нанжингийн номын санд байжээ. Түүнийг Юн ло хаан ач дүүгээ ширээнээс буулгаад 1406 онд нийслэлийг Нанкингаас Бээжинд авчирсан юм» гэж буй [Билгүүдэй 2016].

Тэдгээр сурвалж бичигт тэмдэглэгдсэн «утга учир бүрэн сайн эх» гэж эрдэмтэд үзэж байгаа «Лу Алтан товч»-д байгаа домгийг сонирхвол:

«Олон Монголын төрийг Даймин хаанд автаж, түүнээс хойш ном шашин цөлийдсөн бүлгээ. Хубилай сэцэн хаан Дайдуг сууснаас инагш Ухаант хаан хүртэл нэгэн зуун жил дээр, таван он зургаан сар суугаад Дайдугийн хотыг алдвай гэх. Тэр төр автахуйд, Ухаант хааны Хонгирад хатан гурван сарт хөл хүнд асан аж. Тэр хатан бутун орж хоцров. Тэр бутунг Хятад ган гэх, монгол бутун гэх. Тэр хатныг хятадын Жуюу Хунхуа хаан авч, хан оронд суув. Тэр хатан сэтгэрүүн: ”Долоон барж үзэгдвээс, дайсны хөгүүн гэж тэвчих, арван сар болж үзэгдвээс өөрийн хөвгүү гэж муу үйл хийх гэж тэнгэр эцэг минь өршөөж гурван сар нэмж, арван сар болгож өршөөж соёрх“ гэж залбиран явбай. Тэнгэр өршөөж арван сар болж нуган хүүхэн үзэгдэв.

Жуу Хунхуа хааны хятад хатнаас нэгэн нуган хүү төрөв. Хунхуа хааны зүүдэнд хоёр луу хэрэлдэхүйг үзвээс, баруун лууг зүүн луу дийлэн байхуйг үзэн зүүдлэв. Энэ зүүд минь сайн буюу, муу буюу гэж ёрчинд үзүүлэв. Тэр хоёр луу бус хоёр хүүхэн чинь буй. Баруун луу гэгч хятад хатны хүүхэн буй. Зүүн луу гэгч монгол хаины хөвгүүн буй. Чиний хан оронд суух заяат буюу. Ёрчны тэр үгэнд Хухуа хаан, ялгалгүй мөн үр боловч эх нь дайсны хатан бүлгээ. Үүнээс төрсөн хөвгүүн миний хатан ор сууваас муу байнам гэж хааны ордоос гаргаж, хэрмийн гадна Хөх хот барьж ор сууж, гучин нэгэн он болж, үгүй болов. Түүний хөвгүүн Жагуяа хаан, хан оронд сууж, дөрвөн он болсны хойно, Хонгирадын хатны хөвгүүн Юнло хаан, өөрийн цөөн нөхөд, өлгий зургаан мянган монгол улс, усны гурван түмэн Жүрчид улс, Хар хэрэмийн улсыг аван цэрэг засч хүрээд, Хятадын Хунхуа хааны хөвгүүн Жагуяа хааны барьж хүзүүнд нь мөнгөн тамга дарж, үлдэж орхив. Ёст хаан Юнлогийн домгийн аль ч хувилбарт Жү Юаньжан буюу Хун-ү эзэн хааны зүүдэнд хоёр луу хэрэлдэх бөгөөд баруун луу нь зүүн луудаа дийлдэж байна гэж зүүдэлж байна. Ингэж зүүдлэх нь сайны ёр уу, муугийн ёр уу гэж ёрчинд үзүүлэхэд ёрчин хоёр луу бол хоёр хүүхэд чинь байна. Баруун луу гэгч хятад хатны төрсөн хөвгүүн гэдэг нь бодит түүхэн дэх Юньвэнийг хэлжээ.

Зүүн луу гэгч монгол хатнаас төрсөн хөвгүүн гэж байгаа нь үнэхээр монгол хатнаас төрсөн Жү Ди-ийг хэлсэн болох нь илэрхий байна» [Билгүүдэй 2016]

гэжээ. Үүнээс гадна, сонирхолтой нэгэн жишээ бол тэр домгийн аман хувилбар, аман түүхийн жишээ юм. Их эрдэмтэн Агваанчойдор гуай өгүүлсэн нь:

Тогоонтөмөр хааны хатныг Хятдын Мин улсын хаан Жү Юань Жан авсан болохоор энэ хатныг хятдын түүхэн дээр « Их хөлт хатан гэдэг. Учир нь хятад, эмэгтэй хүний хөлийг боодог заншилтай» болохоор тэр хатан нь монгол учир тэгж дуудаг байна. Тогоонтөмөр хааны хатан нь Мин улсын хаан Жү Юань Жан тай суухад бие хүнд болоод 2 сар болж байсан боловч, тэр хүүхэд нь эхийн гэдсэнд 12 сар гаруй болоод төржээ. Тэгэвч Мин улсын хаан Жү Юань Жан өөрийн хүү гэж сайн итгэхгүй тул тэр хүүг Нанжинд явуулж, бага хүүгээрээ хаан ор тавих гэж байв. Тэгээд Мин улсын хаан Жү Юань Жан гүй болж, бага хүү нь хаан ор эзэлж байв. Их хүү нь « би хэзээ Бээжинд хүрч аавын орд суух бий ?» гэсэнд дүү нь «Ахын сахал ургаад бүсэлхийд хүрэх үед ир!» гэжээ. Ах нь дүүгийнхээ үгээр нилээд хэдэн жил хүлээсэнд сахал нь тийм урт ургахгүй болохоор, үсээ тайрч сахал дээрээ наагаад, «өдгөө миний сахал бүсэлхийдээ хүрэв, би очлоо » гээд Бээжинд ирсэнд дүү нь айгаад үхчихжээ. Тэгээд Мин улсын хааны удмыг монгол угсаатай гэж хэлдэг [Бат 2011: 26].

Эдгээр сурвалж бичиг хийгээд аман домогт Мин улсын Юн Ло хааны уг угсаа хийгээд хаан ор суусан үйл гэргийг тусгахын дагуу бас ямар нэгэн талаар Юань гүрэнтэй холбоотой болохийг өгүүлсэн байна. Тэрчлэн Юн Ло хаанаар зогсоогүй түүний дараа үед бас хаан ор булаагдсан домог байдаг. Тэр домог нь юу гэвэл,

Мин улсын Юн Ло тайж ах дүү хоёр хаан суурь булаалдаж, дүү нь ахаа хорлоно гэж байжээ. Тэгээд ах нь хаан суухаа больж, Ланьжоу- аас Хөхнуурын Жү Цанийн газарт хүрчээ. Тэр үед энэ газарт Жү Лүн Ваа (gro long pa) гэдэг (номын нэр Санжаадаш гэдэг) лам байв. Тэр лам нь их бясалгал хийсэн эрдэмтэй хүн байсан юм. Хятадаар түүнийг усны лам гэх буюу далайн лам гэдэг. Учир нь тэр нэг хөх үхэртэй, Хөхнуурын хүйст суудаг гэртэй, тэр хөх үхрээ унаад, Хөхнуурын дотор ороод хөвөөд явчихдаг байжээ. Тэр угтаа Энэтхэгийн газраас ирсэн лам байсан бөгөөд Хятадын хааны

хөвгүүнийг шавь болгоод, Хятадд шашин дэлгэрүүлэх санаатай байжээ. Тиймээс Мин улсын Юн Ло тайжийг хүрч очиход яг сайхан өглөөний үүр хаяарч байхын үе байв. Энэ үед хэнгэрэг цангийн дуу онцгой тунгалаг бөгөөд соргог, сонирхолтой сайхан байсан учир, Юн Ло тайж тэр бясалгал хийж байсан газарт очжээ.

Тиймээс Жү Лүн Ваа гэдэг лам, Юн Ло тайжийг « нар дэлгэрэх үеэр ирлээ, бэлгэ ерөөлтэй, их гэрэг бүтэх өлзийтэй явдал боллоо » гээд түүнийг тэнд лам болгожээ. Юн Ло тайж гэнэт нэг шөнө үгүй болсноор хүмүүс айж сандарч байсан боловч, эцэсдээ Жү Цанийн бясалгалын агуйд лам болж суусаныг мэдэж, дүү нь санаа амарч Мин улсын хаан болжээ. Дараа нь лам болсон ахдаа Бээжингийн хааны ордтой тэнцэхээр Жү Цан доржичан (gro tshang rdo gje 'chang) хийдийг байгуулж өгчээ. Энэ хийдэд, мөн хийдийн сахил лам болох Жү Лүн Ваагийн түүхийг чулуун пайз дээр «Мин улсын Юн Ло хааны зарлиг» гэж хятад төвд хоёр үсгээр бичсэн нь төвдийн орчуулгын түүхэнд төвдийг хятадд орчуулах гэв дүрэм болж байгаа юм.

Бид төвдийг хятад руу орчуулахад энэ пайзын бичгийг журамладаг. Хятадыг төвд болгоход олон баримт бичиг ном бий боловч, төвдийг хятад руу орчуулахад зөвхөн энэ пайзын бичгээс өөр сайн орчуулаагүй юм. Тэр пайзад орчуулагийн нэг сайн гэв дүрэм (нэг сайн арга)-г бий болгожээ. Тэрчлэн тэр үед Мин улсын хаан Ланьжоуд байжээ. Зарим үед Ший Ань-д байдаг байв. Мин улсын хааны онгон, ихэнх нь Ганьсуй мужийн Тянь шүйд байдаг. Өдгөө хүртэл нээж үзээгүй байгаа гэдэг [Бат 2011: 196–197].

Энэ домог нь Юн Ло хааны дараа үетэй холбогдож байгаа ч гэсэн Бээжинд байгаа хааны ордон (Юань улсын хааны ордон)-тай адил барилга, хэрэмийн зурагтай сүмийг дүү хаан нь ахдаа барьж өгсөн нь сонин байдаг. Тиймээс тухайн үед «Чүй тань Сы хийдэд очсон бол Бээжинд хүрэх хэрэггүй» гэсэн үг бий болжээ [Бат 2011: 178]. Энэ нь Мин улсын хаан нь ямар нэг талаараа Юань улсын хаадтай холбоотой болохыг зааж байна. Мөн Мин улсын хааны онгоныг өдгөө хүртэл нээггүй байдаг ч бас учиртай. Тэр дотор бас түүхийн нууц хадгалагдаж байж ч магад.

Мин улсын хаадын домгоос зах зух дурдахад ийм байна. Гэхдээ Мин улсын эхэн үед Жу Юань Жангийн цэрэг нь Юань улсын үлдэгдэл хүчнийг сөнөөж их хядлага хийж байсан хэрэг олон бий.

Түүнээс зарим хүмүүс нэрээ буруулж өөр үндэстэн болсон ч бий. Нэг жишээг дурдвал Дунсян юм.

Дунсян гэдэг бол газрын байцаар нэрлэсэн нэр юм. Харин энэ үндэстний жинхэнэ нэр нь Сономба гэдэг. Яагаад ийм нэртэй болсон буй гэвээс, Юань улсын үед Сономба гэдэг ноёны цэрэг (30 000 цэрэг) энд сууж байжээ. Уг нь Хэ Тү Сы ийн хүмүүс юм. Юань улс мөхсөний дараа, тэд Хатан голыг гаталж чадалгүй, исламын шашныг шүтэж, Мин улсын цэрэг араас нь хөөж ирэхэд нэрээ өөрчилж, «бид монгол биш, Сономба байна (тухайн үед Сономба гэдэг хүн тэднийг төлөөлж байсан учраас тэд тэгж хэлжээ). Бид исламын шашныг шүтдэг» гэсэнд, Мин улсын цэрэг тэднийг хотон байна гэж бодоод мөн тэр байгаа газарт нь байршуулжээ. Ингээд тэд өөрсдийгөө Сономба гэж нэрлэх болов [Бат 2011: 27].

Энэ мэт Мин улсын эхэн үед нилээд ширүүн дайралдаж байсан боловч, Юн Ло хааны үе буюу түүнээс хойш үед нилээд тогтвортой хөгжсөн байна. Тийм учир Мин улсын эхэн үеийн олон домог уламжилж бий. Жишээ нь өдгөөд мөн Юань улсын үеийн нэгэн цэрэг ийн ноёноор нэрлэж байгаа Ван Бо Бо Чэн гэдэг хотын тухай ийм хэллэг бий.

Юан улсын сүүл үеэр, Ланьжоу хотод нэг өндөр модон суварга босгосон байжээ. Тэр нь энд монголчууд байсны гэрч болгож байв. Сүүлээр нь тэр модон суврага үгүй болж, тэр суврага байсан газрыг «Модон суврагын гудамж» гэж нэрлэжээ. Өдгөө модон суварга нь үгүй боловч, тухайн үед *«Ланьжоуд нэг модон суварга бий, өндөр нь тэнгэрээс нэг тохой найман ямх зайтай»* гэж хуучин хүрээ дотор нь бичиж байжээ.

«Цагаан суварга» хийгээд «Модон суврага»-ын хооронд Хатан гол урсаж буй. Энэ хоёр суваргаас дээш монголын газар байв. Үүний баримт нь энэ хоёр суврагаас дээш Ван Бо Бо Чэн гэдэг хот бий. Ван Бо Бо (монгол нэр нь Төмөр гэдэг) бол Юань улсын хамгийн сүүлчийн хаан Тогоонтөмөрийн цэргийн нэгэн ноён байв.

Юань улсын үед энэ хотод Хятад хүнийг оруулахгүй чанга сахидаг байжээ. Гагцхүү цагаан сарын шинийн найманд, баяр дурсгалын өдөр болохоор «тэдэнд баяр наадам хүргэж байна» гээд

Шүй Хүй тоглодог хүмүүсийг Хятадын талаас очуулдаг байв. Нэг удаа тэдгээрийг хотын хүрээн дотор оруулжээ. Гэтэл тэдгээр Шүй Хүй тоглодог амьтасын барьж явсан дарцаг цөм жад байж, бас хэнгэрэг дотроо хутга сэлэм (тэр үед буу байсангүй, жад сэлэм байдаг байжээ) нууж ороод, бүжиг тоглож байснаа гэнэт бослого гаргаж, найр хийж идэж ууж байсан хүмүүсийг алж, мөн тэдний араас нь цэрэг ороод энэ газрыг Хятад эзлэх болжээ.

Түүнээс хойш тэр хэнгэрэг Тай Пэн Гү гэж нэрлэсэн байна. Энэ нэр нь «Энх тайван болгосон хэнгэрэг» гэсэн утгатай. Өдгөө жил бүр 3 сарын 25-д Тоорын цэцэг үзэх гэж цугларна. Үүнийг Хятадаар тоорын цэцэгт цуглаан гэдэг. 8 сарын 15-д тоор иднэ гэж бас цугларна. Цагаан сарын 8-15 хүртэл Шүй Хүй тоглоно. Ван Бо Бо гэдэг нэр нь үлдэж, мөн тэр нэрээр хотыг нэрлэж бий. Энэ хотоос цааш яваад урт цагаан хэрэмд залгадаг юм [Бат 2011: 156–157].

Дээр дурдсан домгийн аль нь ч тэр, Мин улсын эхэн үе нилээд ширүүн байсаныг харуулж байна. Мөн үүнтэй холбогдуулан, Ёст Юн Ло хааны домогт гарч буй «Хоёр луу хэрэлдсэн » гэх өгүүлэмжийн талаар хэдэн мөр зарцуулъя. Энэ тухай эрдэмтдийн зохиолд: «Энэ домгийн уран сайхны онцлог гэж төдий л ярих зүйлгүй. Хятадын зан ёсонд нийцүүлэн хаадын эрх булаалдсан тэмцлийг хоёр луу хэрэлдсэнээр зүүдэлсэн болгож үзүүлсэн нь домгийн гол уран сэтгэмжийн зүйл болно. Мөн төрөх үрийг дайсны хаанд эс мэдэгдэхийн учир тэнгэрт залбирч нярайлах хугацааг 13 сар хүртэл хойшлуулсан гэдэг бол домогт их л дэлгэрсэн ердийн уран сэтгэмжийн зүйл бөгөөд гэдсэн дэх хүүхэд ийн өсөлтийн удаашралтай холбогдсон бодит зүйлээс гаралтай биз » гэжээ [Дамдинсүрэн, Цэнд 1983: 337].

Энд дурдаж байгаа луугийн талаар бас аман хэллэг бий. Жишээлбэл, Ланьжоу хот нь Лань Шань уулын хормойд, хаа эртээс цуутай Хатан голын хөвөөнд оршино. Лань гэдэг нь холоос аварга луугийн дүрстэй харагддаг учраас ийнхүү нэрлэсэн гэх. Тэр ч байтугай Мин улсын тэргүүн онд лууг дахин босхоос сэрэмжилж сүүлийг нь тас цохисон юм хэмээн нутгийнх нь өвгөчүүд өгүүлэх ажээ [Бат 2011: 260]. Энд луу гэдгээр монголыг төлөөлж байгаа

санаа ил байхаар барахгүй, Чингис хааны тамгыг төвд сурвалж бичигт бас луутай холбож өгүүлсэн бий.

Бодит өгүүлэмж хэллэг нь ийм байна. Чингис хааныг төвдийн түүх бичлэгт «Жингэр Жалбу » (jing gir rgyal po, энэ нь жингар ноён гэсэн утгатай) гэж тэмдэглэдэг байна. Үүнд Жалбу гэдэг нь ноён, хаан гэсэн утгатай юм. Харин «Жингэр» гэдэг үг нь яаж ирсэн бий гэвэл, Чингис, хаан суухад нэг шувуу ирч, чулуун дээр суугаад «жингэр», «жингэр» гэж дугарснаар Чингис хаанд тийм нэр өгжээ. Тэгээд төвдөд Чингис хааныг «Жингэр» гэж нэрлэдэг юм. Тэр шувуу ирж, «жингэр», «жингэр» гэж дуугарсан чулуугаас хас тамга гарч ирсэн юм [Бат 2011: 117]. Энэ тамгын тухай төвдөөр бичсэн монгол сурвалж бичигт «тэр шувуу суусан гүр чулууныг гайхамшиг болов гэмээн балбачин үзээд гол дундаас нь нэг төө хиртэй чулуу авч, ар бие нь яст мэлхийн дүрстэй, дээд бие дээр нь хоёр луу сүлбэлдсэн тамга зохион үйлджээ» гэж тэмдэглэсэн байна [Баясгал 1997: 71].

«Тэр тамгыг хүн хийсэн биш, чулуугаас гарч ирсэн болохоор, Чингис хаан их хүчтэй байж, дэлхийг эзэлсэн юм. Тамга дотор хамгийн их хүчтэй гэдэг нь Чингис хааны тамга болох хас тамга юм. Түүний дараа, алт, мөнгө, зэс, төмөр буюу модоор хийсэн тамга бий. Тамгыг хийсэн бодсын материалаар хууль нь тийм зэрэг хүчтэй явагддаг байсан юм гэж урдын хүн үздэг байна. Тиймээс өдгөө модон тамгатай болсноор хууль нь зөөлөн бөгөөд худал хуурмаг юм арвидаж, үйл ажиллагаа нь найдвартай явагдахгүй болжээ» [Баясгал 1997: 71].

Эдгээрээс үзвэл, домгийн дүрслэлд «Зүүн луу нь баруун лууг дийлэх», «лууг дахин босохоос сэрэмжилж сүүлийг нь тас цохисон» гэх мэт зүйл нь адилхан Ёст Юн Ло хаан хийгээд монголчуудтай холбогдож байна. Нөгөө талаар «хоёр луу хэрэлдсэн» гэх өгүүлэмжид Мин улсын эхний үеийн монгол хятадын тэмцлийг гүн харуулсан байгаа билээ.

Ерөнхийлөөд хэлбэл, Мин улсын хаадын тухай домог нь тархацын талаар аман ба бичигт уламжилж, монголчуудын дунд гүн зузаан хоногшин дэлгэрч ирчээ. Тэгээд тэдгээр домог нь монголчуудын домог зүйн уламжлал, монгол хаадын ёс, мөн Мин

улсын хаадын бүхий л түүх, төр гүрний уламжлал ёс зэргийг нийтдээ тусгаж, бичиг ба аман уламжлалын сонирхолтой жишээ болж, Мин улсын үе дэх ардын домог үлгэр жич монгол түмний өвөрмөц соёлын нэгэн үзэгдэл болж ирснээр түүнийг судалж шинжлэхийн учир утга нь тодорхой байна.

Ном зүй

- Бат 2011 — *Бат Д.* Агваанчойдорийн ярьсан монгол төвөд бурхан шажины аман түүх. Бежин: Үндэстэний хэвлэлийн хороо, 2011. 320 х.
- Бат 2016 — Бат Д. Агваанчойдор гуайн ярьсан аман түүх хийгээд Халх, Ойрдын зарим түүхт хүмүүсийн домог. Хэрийн судлаалын материал, 2016.
- Баясгал 1997 — *Баясгал.* Дээд монголын түүхэн сурвалж бичгүүд. Лионин: Үндэстэний хэвлэлийн хороо, 1997. 508 х.
- Билгүүдэй 2016 — *Билгүүдэй Г.* Монголын эртний уран зохиолын хоёр өгүүлэмжийг түүхэн эх сурвалжаар тодруулах нь // Монгол уран зохиолын өгүүлэмжийн судалгаа. Улаанбаатар: Хэл зохиолын хүрээлэн ШУА, 2016. Х. 64–81.
- Дамдинсүрэн, Цэнд 1983 — *Дамдинсүрэн Ц., Цэнд Д.* Монголын уран зохиолын тойм. Дээд дэвтэр. Хуххот: Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1983. 690 х.
- ХСМ–1 — Хэрийн судлаалын материал. Алша баруун хошууны Алдцаг сумын Ногоонбулаг гацааны малчин Осор ярив.
- ХСМ–2 — Хэрийн судлаалын материал. Алша баруун хошууны Алдцаг сумын Ногоонбулаг гацааны малчин Бүд ярив.